



**ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦӨГТ СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 03 сарын 14 өдөр

Дугаар Мж

Амардалай

**Орон тооны бус зөвлөл байгуулах тухай**

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 71 дүгээр тогттоолоор баталсан "Малчинд тэтгэвэр тогтооход баримтлах журам"-ын 3.3, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн A/77 тоот тушаалаар баталсан "Даатгуулагчийн малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөлийн дүрэм"-ийн 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ:**

1. Даатгуулагчийн малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: С.Нарантунгалааг (Засаг даргын Тамгын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Х.Оюунчимэг (Нийгмийн даатгалын байцаагч)

Гишүүд: П.Амгаланбаатар (Баянбулаг багийн дарга)

Г.Сосорбурам (Цахиурт багийн дарга)

Б.Баатарсүрэн (Дэлгэр-Эмт багийн дарга)

О.Улаанхүү (Иргэний төлөөлөл)

Д.Наранцэцэг (МЭҮТ-ийн дарга)

2. Даатгуулагчийн малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөлийн дүрэм болон бусад хууль журмыг хэрэгжүүлж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударгаар ажиллахыг орон тооны бус зөвлөлийн дарга гишүүдэд үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2018 оны 04 сарын 12-ны өдрийн A/31 тоот захирамжийг хүчингүйд тоодсугай.

ДАРГА М.БАЯРСҮХ

**4880700510**